



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар Б/78

Хэрлэн сум


Шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3 дахь заалт, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид шагнал, урамшуулал олгох журам"-ын 5,9-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгт сумын тусгай мэргэжлийн анги, аж ахуй нэгж байгууллагын бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ой хээрийн түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлж удирдлага зохион байгуулалтаар нэгтгэн ажиллуулсан Баян-Овоо сумын Засаг дарга Д.Баянмөнх, Дадал сумын Засаг дарга Д.Оюунбаатар, Дэлгэрхаан сумын Засаг дарга О.Анхбат, Баянхутаг сумын Засаг дарга Д.Байгалмаа нарын албан тушаалын сарын үндсэн цалинг 1 сарын хугацаагаар 20 хувиар урамшуулсугай.

2. Шагналд шаардагдах хөрөнгийг байгууллагын төсвийн холбогдох зардлаас зарцуулахыг сумдын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА